

Mongolian Kitamura Portions

Mongolian Kitamura Version

2020

Mongolian Kitamura Portions Mongolian Kitamura Version

Portions of John in the Mongolian Kitamura language. This Bible is printed with permission and produced at cost by the Digital Bible Society (dbs.org) for non-commercial use.

This Bible, and many others, are available for free download in a variety of digital formats at dbs.org/bibles.

Language: Mongolian
Country: Mongolia
Publisher: Akihide Kitamura (ThruSteppes)
Copyright: © 2020, Akihide Kitamura
Last Updated: 2022-10-28
ID: MONAKK
ISO: mon
ISBN:



1-р бүлэг

¹ Есус Христийн баярт мэдээ ингэж эхэлсэн билээ. ² Урьд Бурханы үг дамжуулагч Исая “Би чиний өмнө элчээ илгээж Замыг чинь бэлтгүүлье. ³ Их цөлд хүний дуу хадаж Эзэний замыг бэлтгэж, Эгцлэн шулуутга хэмээв.”

гэж бичсэн ажээ. Энэ мэтээр ⁴ усны ёслол үйлдэгч Йохан хээр гараад тунхаглаж,
— Нүглээ гэмшиж усны ёслолыг хүрт. Тэгвэл Бурхан та нарын нүглийг уучилна гэв.

⁵ Иудейн бүх орны олон хүн, ялангуяа Иерусалимд суугчид Йохан дээр ирээд үйлдсэн гэм нүглээ наманчилж, Иордан голд түүгээр усны ёслол үйлдүүлэв. ⁶ Йохан бол тэмээний ноосоор хийсэн хувцсаа суран бүсээр даруулан бүсэлж, царцаа, хээрийн зөгийн балаар хооллодог байжээ. ⁷ Тэр тунхаглан хэлэв.

— Надаас хүндтэй хүн хожим ирнэ. Би бол бөхийн түүний шаахайн үдээсийг тайлахад ч зохисгүй хүн. ⁸ Би усаар та нарт энэ ёслолыг үйлддэг. Харин тэр хүн Ариун Сүнсээр та нарт энэ ёслолыг үйлдэнэ.

⁹ Тэр үед Есус Галилын Назар тосгоноос гараад Иордан голд Йоханаар усны ёслол үйлдүүлээ. ¹⁰ Тэгээд тэр уснаас гармагц тэнгэр онгойж, Ариун Сүнс тагтаа мэт өөр лүү нь бууж ирэхийг харлаа. ¹¹ Тэгэхэд

— Чи бол миний хайрлаж байгаа, санаанд минь таарсан хүү мөн гэсэн дуу тэнгэрээс гарлаа.

¹² Тэр даруй Ариун Сүнс Есусийг цөл рүү явуулав. ¹³ Есус дөч хоног тэнд байжээ. Сатан түүнийг гэм нүгэлд өдөөх гэж хичээж байв. Тэр үед Есус адгуусан амьтадтай хамт байсан бөгөөд Бурханы элч нар түүнд үйлчилж байв. ¹⁴ Йоханыг баривчлагдсаны дараа Есус Галилд ирж, Бурханаас хүртсэн баярт мэдээг тунхаглаж, ¹⁵ Одоо Бурханы захирах цаг эхэллээ. Гэмшиж, баярт мэдээнд итгэ гэж хэллээ. ¹⁶ Есус Галил нуурын эргээр явж байхдаа Симон, түүний дүү Андрег усанд тор хаяж байгааг харлаа. Тэд загасчид байв.

— ¹⁷ За, намайг дагаад яв. Би та нарт хүнийг яаж авчрахыг зааж өгье гэж Есусийг хэлмэгц ¹⁸ тэд тороо орхиод түүнийг дагажээ. ¹⁹ Бас тэндээс жаахан цааш яваад, Зебедайн хоёр хүү Яков, Йохан нар завин дотроо тороо засаж байгааг харлаа. ²⁰ Тэгээд Есус тэднийг дуудахад тэд өөрийн эцэг Зебедайг хөлсний загасчидтай нь хамт завиндаа үлдээгээд түүнийг дагав. ²¹ Ингэж тэд Кафарнаумд хүрлээ. Амралтын өдөр болоход Есус шууд нутгийн сүмд ороод, хүмүүст сургаалаа зааж эхэллээ. ²² Хүмүүс түүний сургаалыг сонсож ихэд гайхлаа. Яагаад гэвэл тэр хуулийн багш мэт биш, харин эрх баригч мэт

заажээ. ²³ Тэгэхэд өнөө сүмийн дотор бузар чөтгөр шүглэсэн нэг хүн байсан бөгөөд тэр ингэж хашгирч эхэллээ:

— ²⁴ Назар тосгоны Есус ээ! Битгий бидний хэрэгт оролц! Чи биднийг сөнөөхөөр ирсэн үү? Би чиний хэн болохыг мэднэ. Чи Бурханы илгээсэн ариун нэгэн мөн.

— ²⁵ Дуугүй бай. Энэ хүнээс тонил гэж Есусийг зандрахад, ²⁶ бузар чөтгөр тэр хүнийг татвалзуулсаар, чанга дуугаар хашгирч салан одов. ²⁷ Тэгэхэд хүн бүхэн гайхаж,

— Юу болж байна аа! Энэ бол эрх мэдэлтэй шинэ сургаал юм байна. Тэр хүн тушаавал бузар чөтгөр ч түүний үгийг дагадаг юм байна шүү гэж хэлэлцэв. ²⁸ Ингэж Есусийн тухай яриа даруй бүх Галил орноор тарлаа. ²⁹ Тэд сүмээс гарсан даруйдаа Симон, Андре хоёрын гэрт очлоо. Яков, Йохан хоёр ч тэдэнтэй хамт очжээ. ³⁰ Симоны хадам эх халуураад хэвтэж байсан учир хүмүүс үүнийг Есуст хэлэв. ³¹ Есус түүний хажууд очиж гары нь барьж босгоход халуун нь буурч, тэрээр тэднийг зочлов. ³² Орой болж нар жаргасны дараа хүмүүс өвчтөн болоод чөтгөр шүглэсэн хүн бүхнийг Есуст авчирлаа. ³³ Ингэсээр хаалганы өмнө тэр хотын бүх хүн цуглав. ³⁴ Есус янз бүрийн өвчтэй олон хүнийг эдгээгээд, олон чөтгөрийг хөөж гаргав. Тэгэхдээ Есус чөтгөрийн юм хэлэхийг ч хориглов. Яагаад гэвэл чөтгөрүүд Есусийн хэн болохыг мэдэж байв. ³⁵ Өглөө болохоос өмнө бүрий байхад Есус босож эзгүй газар очоод, тэнд залбирч байв. ³⁶ Симон нөхөдтэйгээ Есусийг эрэхээр гарч ³⁷ түүнийг олоод,

— Бүгд таныг эрж байна гэв. ³⁸ Есус тэдэнд хариулав:

— Эндээс ойр байгаа өөр хот тосгонд ч очъё. Би тэнд ч баярт мэдээг дэлгэрүүлъя. Тэгэхийн тулд би ирсэн. ³⁹ Ингэж Есус бүх Галилын нутгийн сүмүүдэд очоод баярт мэдээг дэлгэрүүлж чөтгөрүүдийг хөөн гаргажээ. ⁴⁰ Нэг уяман өвчтөн Есус дээр ирээд сөгдөж,

— Хэрэв та таалбал намайг эдгээж чадна гэж хэлэв. ⁴¹ Есус өрөвдөн, сунгасан гараа түүнд хүргэж,

— За, би эдгээж өгье гэж хэлмэгц ⁴² уяман өвчин нь эдгэрлээ. ⁴³ Даруй Есус түүнийг явуулахдаа хатуу тушаан ⁴⁴ ингэж хэлжээ:

— Хэнд ч, юу ч хэлж болохгүй. Зөвхөн тахилчид очиж биеэ үзүүл. Та эдгэрсэн учир Мосегийн тушаасан зүйлийг Бурханд өргөж, эдгэрснээ хүмүүст гэрчил. ⁴⁵ Харин тэр хүн очоод юу болсноо олон хүнд хэлж, дэлгэрүүлж эхэллээ. Тийм учраас Есус түүний дараа олон хүний өмнө хотод орж чадахгүй болж,

хотын гаднах эзгүй газар байжээ. Тийм боловч хүмүүс түүнийг зорин газар бүрээс цуглан ирэх болов.

2-р бүлэг

2 Есусийг дахин Кафарнаумд ирснээс хэдэн өдрийн дараа хүмүүс түүнийг гэртээ байгааг мэдлээ. ²Тэгээд дэндүү олон хүн цугласан учир үүдээр багтаж орох ч аргагүй болжээ. Есусийг тэдэнд сургаалаа зааж байхад, ³ дөрвөн хүн саа өвчтэй хүнийг үүрч авчирлаа. ⁴ Харин тэнд олон хүн байсан бөгөөд Есус ойтлуулан аваачиж чадсангүй учир Есусийн байгаа газрын дээрх дээврийг ховхолж нүхлээд, өвчтөнийг хэвтэж байгаа дэвсгэртэй нь буулгажээ. ⁵ Есус тэдний өөрт нь итгэж байгааг хараад, саа өвчтэй хүнд

— Хүү минь, чиний гэм нүгэл уучлагдсан гэж хэллээ. ⁶ Тэгэхэд тэнд сууж байсан хэдэн хуулийн багш ингэж эрэгцүүлэн боджээ: ⁷ Тэр хүн яагаад ингэж хэлдэг юм бэ? Тэр Бурханыг доромжилж байна. Бурханаас өөр хэн нүглийг уучилж чадах юм бэ? ⁸ Есус тэдний юу бодож байгааг даруй тааж мэдээд ингэж хэллээ:

— Та нар яагаад тэгж бодно вэ? ⁹ Саа өвчтэй хүнд “Таны нүглийг уучилна” гэж хэлэх, эсвэл “Бос, дэвсгэрээ үүрээд алх” гэж хэлэхийн аль нь илүү амархан бэ? ¹⁰ Хүний хүү дэлхий дээр нүглийг уучлах эрх мэдэлтэй байгаагаа та нарт үзүүлье.

Тэгээд Есус саа өвчтэй хүнд хандаж, ¹¹ Би танд хэлье. Бос! Дэвсгэрээ үүрээд гэртээ харь гэв. ¹² Тэгтэл тэр босож, даруй дэвсгэрээ үүрэн, хүн бүгдийг харж байхад гадагш гарлаа. Бүх хүн гайхаж,

— Өдий хүртэл бид ийм юм үзээгүй гэж хэлээд Бурханыг магтлаа. ¹³ Есус дахин нуурын эрэгт очлоо. Олон хүн түүн дээр ирсэн тул тэр тэдэнд сургаалаа заажээ. ¹⁴ Тэгээд Есус замаар явж байхдаа Алфайн хүү Левийг татвар авах газарт сууж байгааг нь хараад,

— Намайг дагаад яв гэж хэлэхэд, тэр босож түүнийг дагажээ. ¹⁵ Есусийг түүний гэрт хоол идэж байхад олон татвар хураагч ч, нүгэлтэн ч Есус болон түүний шавь нартай хамт байжээ. Энэ мэтээр Есусийг дагагч олон болов. ¹⁶ Фарисай бүлгийн хуулийн багш нар Есусийг нүгэлтэн, татвар хураагчидтай хамт хоол идэж байгааг хараад түүний шавь нараас

— Тэр юунд татвар хураагчид болон нүгэлтэнтэй хамт хоол иднэ вэ? гэж асуув. ¹⁷ Есус үүнийг сонсоод,

— Эрүүл хүнд биш, харин өвчтэй хүнд эмч хэрэгтэй. Би өөгүй хүнийг урих гэж ирсэн биш, харин нүгэлтнийг урихын тул ирлээ гэж хариулав. ¹⁸ Йоханы шавь нар болоод Фарисай бүлгийн хүмүүс мацаг барьдаг байжээ. Тийм учраас хүмүүс ирээд Есусээс асуув:

— Йоханы шавь нар, Фарисай бүлгийн шавь нар ч мацаг барьж байхад таны шавь нар яагаад мацаг барьдаггүй юм бэ? ¹⁹ Есус тэдэнд ингэж хариулав:

— Хуримын зочид хүргэн болох хүнтэй хамт байхдаа мацаг барьж чадах уу? чадахгүй шүү дээ. ²⁰ Харин тэр хүн тэднээс салах цаг ирнэ. Тэр өдөр тэд мацаг барих биз дээ. ²¹ Хуучин хувцсаа нөхөхдөө хэн ч шинэ даавуунаас хайчилж авахгүй. Хэрвээ тэгвэл шинэ даавуу хуучин хувцсыг урж, цоорхой нь улам том болно. ²² Бас хэн ч усан үзмийн шинэ дарсыг хуучин туламд хийхгүй. Хэрвээ тэгвэл усан үзмийн дарс тулмыг цоолж, дарс ч, тулам ч хэрэглэх аргагүй болно. Усан үзмийн шинэ дарсыг нь шинэ туламд хийх хэрэгтэй. ²³ Нэгэн амралтын өдөр Есусийг буудайн талбайд явж байтал шавь нар нь явсаар буудайн түрүү зулгааж эхэллээ. ²⁴ Тэгэхэд Фарисай бүлгийн хүмүүс Есусээс ингэж асуув:

— Яагаад тэд амралтын өдөр хийж болохгүй зүйлийг хийж байгаа юм бэ? ²⁵ Есус тэдэнд ингэж хариулав:

— Идэх юмгүй болоод Давид болон түүнийг дагагчид өлсөж байхдаа түүний юу хийснийг та нар ерөөсөө уншаагүй юү? ²⁶ Абиятарыг дээд тахилч байхад Давид улсын сүмд ороод, тахилчдаас өөр хүний идэж болохгүй өргөлийн талхыг идэж, дагагчдаа ч өгсөн биш үү? ²⁷ Тэр бас ингэж хэлэв:

— Амралтын өдрийг хүний төлөө тогтоосон юм. Хүн амралтын өдрийн төлөө бүтээгдсэн биш билээ. ²⁸ Тийм учраас Хүний хүү амралтын өдрийг захирагч мөн.

3-р бүлэг

3 Есус дахин нутгийн сүмд орлоо. Тэнд нэг гар нь мэдээгүй болсон хүн байжээ. ² Хүмүүс Есусээс өө сэв эрж, Есус амралтын өдөр тэр өвчтөнийг эдгээх эсэхийг анхааран ширтэж байжээ. ³ Есус гар нь мэдээгүй болсон хүнд

— Босоод наашаа ир гэж хэлээд, ⁴ тэнд байсан хүмүүсээс ингэж асуув:

— Хуулиар амралтын өдөр сайн юм үйлдэхийг зөвшөөрсөн үү, эсхүл муу юм үйлдэхийг зөвшөөрсөн үү? Амь аврахыг зөвшөөрсөн үү, эсхүл алахыг зөвшөөрсөн үү?

Тэд дуугүй байсан учир ⁵ Есус ууртайгаар тэднийг тойруулан харлаа. Тэдний зөрүүд зантайд Есус гутарлаа. Тэгээд Есус тэр хүнд

— Гараа сунга гэж хэлэв. Тэр хүнийг гараа сунгахад гар нь эдгэрлээ. ⁶ Фарисай бүлгийн хүмүүс тэндээс гараад даруй Херод бүлгийнхэнтэй уулзаж, “Есусийг яаж үгүй хийх вэ?” гэж зөвлөлдөж эхэллээ. ⁷ Есус шавь нарынхаа хамт нуурыг зүглэн холдоход, Галилаас ирсэн маш олон хүн түүнийг дагав. Бас Иудей, ⁸ Иерусалим, Идумая, Иордан голын цаад тал, Тир болон Сидоны хавиас ч маш олон хүн Есусийн юу хийж байгааг дэлгэрэнгүй дуулаад, түүний байсан газарт цуглаж ирлээ. ⁹ Есус энэ олон хүнд шахагдахгүйн тул шавь нартаа “Завь бэлтгэ” гэж тушааж завийг тэнд тавиулав. ¹⁰ Учир нь Есус олон өвчтөнийг эдгээсэн тул өвчтэй хүн бүхэн түүнд гараа хүргэе

гэж түүний зүг түлхэлцэж байлаа. ¹¹ Бузар чөтгөрүүд Есусийг хараад сөгдөж,
— Та Бурханы хүү мөн гэж хашгирцгаав. ¹² Есус “Миний хэн болохыг битгий хэл” гэж бузар чөтгөрүүдэд хатуу тушаажээ. ¹³ Есус ууланд гараад өөрийн санаанд таарсан хүмүүсийг дуудахад, тэд түүний дэргэд цуглав. ¹⁴ Тэгээд Есус сонгон авсан арван хоёр хүнээ “элч” гэж нэрлэжээ. Есус тэднийг өөрийн хажууд байлгах болж, бас баярт мэдээг дэлгэрүүлэхийн тул тэднийг илгээж, ¹⁵ чөтгөрийг хөөж гаргах хүчин чадлыг ч тэдэнд өгөв. ¹⁶ Өнөө арван